



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/163

Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Иргэний хуулийн 531 дүгээр зүйлийн 531.2, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4-р баг, Шивээт 3 гудамж, 95 тоот хаягт оршин суугч Хансан Доржсүрэн (ЙР67072831) нь өөрийн эзэмшлийн 3-р баг, Бэрх, Агьтын аманд байрлах 0000218798 тоот гэрчилгээний дугаартай, 6211003628 тоот нэгж талбарын дугаартай “Өвөлжөө, хаваржаа”-ны зориулалттай 700м² газрыг Өвөрхангай, Хужирт 1-р баг, Өвөрмодот тоот хаягт оршин суугч Ёндон Батбаяр (ЙС62072015)-ын эзэмшилд шилжүүлэх хүсэлт гаргасан тул дээрх газрыг Ёндон Батбаяр (ЙС62072015)-т “Өвөлжөө, хаваржаа”-ны зориулалтаар 44 жил 8 сарын хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Дээрх захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/78 дугаар “Газар эзэмших эрх шинээр олгох тухай” захирамжийн холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДЭМБЭРЭЛ

622301327

D:Alban bichig;Zahiramj 2023